

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

“АЛСЫН ХАРАА – 2050” УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БАРИМТ БИЧИГТ БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР ТУССАН ХОЛБОГДОХ ЗААЛТЫН БИЕЛЭЛТ

2023 оны 02 дугаар сарын 17

Улаанбаатар хот

Хүрэх үр дүн: 1. Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлж, бүтээн байгуулалт хийж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана.

Нийслэлийн хэмжээнд биеийн тамир, спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 2019 онд 60мкв байсан бол 2020 онд 60.5мкв, 2021 онд 61м2, 2022 онд 62мкв болсон. Үүнд:



2013 оноос эхлэн Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороонд спорт цогцолбор барихаар нийт 14,500,000,000 төгрөг зарцуулснаар 2020 оны 06 дугаар сард 1000 хүний суудалтай спорт цогцолборын А, В блок ашиглалтад орсон. Тус цогцолбор ашиглалтад орсонтой холбогдуулан орон нутгийн төсвөөс 2022 онд хоккейн хэрэглэл материалд 20,000,000 төгрөг, фитнес тоног төхөөрөмжид 19,000,000 төгрөг зарцуулсан.

2021 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хороонд битүү дээвэртэй “Steppe Arena” өвлийн спортын ордон ашиглалтад орсон.



2013 оноос Баянгол дүүргийн 15-р хороо



хороонд 650 хүний суудалтай спорт цогцолбор барихаар улсын төсвөөс нийт 9,500,000,000 төгрөг зарцуулснаар 2022 онд ашиглалтад орсон. Тус цогцолбор ашиглалтад орсонтой холбогдуулан 2022 онд дүүргийн төсвөөс 10,500,000 төгрөг, нийслэлийн төсвөөс 23,134,000 төгрөгийн техник, тоног төхөөрөмж худалдан авсан

2022 онд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Баянгол дүүргийн 3-р хороонд 3000 хүний суудалтай “UG Arena” спорт ордон ашиглалтад орсон.



Хэрэгжилт 100%

9.1.17. Орчин үеийн техник, технологийн дэвшлийг биеийн тамир, спортын ажил, үйлчилгээнд нэвтрүүлснээр бүх насны иргэд хиймэл оюун ухаанд суурилсан спортын зөвлөн туслах үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.

Орчин үеийн техник, технологийн дэвшлийг биеийн тамир, спортын ажил, үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг 2040-2050 онд хэрэгжүүлэхээр “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт тусгасан. Тус ажлын хүрээнд “Улаанбаатар марафон-2022” олон улсын гүйлтийн бүртгэл, төлбөр хураамж, амжилтыг технологийн дэвшлийг ашиглан цахим хэлбэрээр бүрэн автоматжуулж 23690 тамирчин, иргэдийг бүртгэсэн.

Мөн худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн эрх, үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, үйл ажиллагааг нь бүртгэж цахимжуулах, мэргэжлийн хяналт тавих зорилготой “Онлайн бизнес төв” платформын Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем /<http://service.ulaanbaatar.mn/home/>-ийн 74 нэр бүхий үйлчилгээнд биеийн тамир, спортын салбарын “бассейн”, “фитнес, спенинг”, “аэробик, иог, бүжгийн клуб”, “боулинг”, “бильярд” гэсэн 5 чиглэлийн үйлчилгээ орсон бөгөөд 2022 онд 28 аж ахуйн нэгж байгууллага, хувь хүн бүртгүүлснээс зөвшөөрсөн 4, батлуулахаар шилжүүлсэн 15, буцаасан 7, судалж байгаа 2 хүсэлт байна.

Хэрэгжилт 100%

9.1.18. Хотын хэмжээнд бүх насны иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, биеийн тамир спортын барилга байгууламжийг төлөвлөн байгуулна.

Стандарт шаардлагад нийцсэн биеийн тамир, спортын гадна талбай 2019 онд 94 байсан бол 2020 онд 1-ээр нэмэгдэж 95, 2021 онд 6-аар нэмэгдэж 101, 2022 онд 4-өөр нэмэгдэж 105 болсон. Үүнд:

2020 онд Багануур дүүргийн Гүн галуутай сургуулийн гадна хөлбөмбөгийн талбай байгуулж нийслэлийн төсвөөс 274,500,000 төгрөг зарцуулсан.


2021 онд нийслэлийн төсвөөс 810,000,000 сая төгрөг зарцуулан Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн орон сууц, гэр хорооллын дунд 3*3 сагсан бөмбөгийн 6 талбай, Сүхбаатар дүүргийн 24 дүгээр сургуулийн гадна талбайг хөлбөмбөгийн талбайгаар шинэчлэн байгуулсан.

2022 онд Хан-Уул дүүргийн 8-р хороонд Хөлбөмбөгийн талбай бүхий техникийн төвийг ашиглалтад оруулан улс, нийслэл, хувийн хэвшлээс 5,684,400,000 төгрөг, Олон

улсын хөлбөмбөгийн холбооноос 5,693,300,000 төгрөг зарцуулсан бол Сүхбаатар дүүргийн 2-р сургууль, Хан – Уул дүүргийн 34, 52-р сургуулиудын гадна талбайг шинээр тохижуулахад орон нутгийн төсвөөс 125,700,000 төгрөг зарцуулсан.



Нийслэлийн шинэ дэд төвүүдэд баригдах спорт цогцолборын барилга байгууламжийг нэг эх загварын дагуу гүйцэтгэхээр “Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн багтай хамтран зургийн даалгаврыг гарган өгч Бодь Пропертийз ХХК-иар хийлгэж 2020 онд батлуулсан. Дээрх нэг маягийн эх загвар зургаар Баянхошуу дэд төв буюу Сонгинохайрхан дүүргийн 40 дүгээр хороонд баригдах 650 хүний суудалтай спорт цогцолборын барилгын гүйцэтгэгч байгууллагаар “Стандарт холдинг” ХХК, “Химон констракшн” ХХК болон “Таны зам” ХХК-иуд 2021 онд гүйцэтгэгч байгууллагаар шалгарч 2022 онд 3 блокын суурийн болон зоорын давхрын цутгалтыг бүрэн хийж дуусгаж, барилга угсралтын ажил үргэлжилж байна. Ингэснээр барилгын нийт ажлын 50 хувийг гүйцэтгэсэн байна.



Хэрэгжилт 90%

9.3.48. Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, томоохон спортын наадмыг зохион байгуулах шаардлага хангасан, олон улсын жишигт нийцсэн 30,000-40,000 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн барьж байгуулна.

Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1046 дугаар “Газар эзэмших эрх олгох тухай” захирамжаар Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрших 30.0 га газарт “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн” байгуулах зориулалтаар 15 жилийн хугацаатай газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт олгосон боловч тухайн газар Байгаль орчны яаманд олгосон газруудтай давхцалтай байсан тул Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 07 тоот тушаал, Барилга хот байгуулалтын

сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ны 36 тоот тушаалаар дэд ажлын хэсгүүд байгуулагдан газрын маргаан, зөрчлийг шийдвэрлэхээр ажиллаж байгаа ч бүрэн шийдвэрлэгдээгүй байна. “Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн”-гийн зураг төсөв хийх ажлын зардал 2022 оны улсын төсөвт 500.0 төгрөг тусгагдсаны дагуу тус ажлыг гүйцэтгэх байгууллагуудын жагсаалтыг гаргасан.

Хэрэгжилт 30%


9.5.14. Олон улс, тив, дэлхийн томоохон наадмуудыг хүлээн авч зохион байгуулах шаардлага хангасан спортын барилга байгууламжийг барина.

“Улаанбаатар 2023” Зүүн Азийн Залуучуудын наадмыг зохион байгуулахад зориулан дараах 2 бүтээн байгуулалтын ажлыг “Улаанбаатар спорт менежмент” ХК хариуцан гүйцэтгэж байна. Үүнд:

“Хөлбөмбөгийн ногоон талбай бүхий техникийн төв” барихаар Олон Улсын хөлбөмбөгийн холбоо (FIFA)-оос Монголын Хөлбөмбөгийн холбоонд олгосон санхүүжилтийн хүрээнд 2020.03.31-нд хамтран ажиллах гэрээ байгуулснаар барилга угсралтын ажил бүрэн дууссан, гадна шугам сүлжээ (дулаан, цэвэр, бохир) цахилгаан, холбоо дохиоллын эх үүсвэрт холбох ажил хүлээгдэж байгаа бөгөөд нийт гүйцэтгэл 98 хувьтай үргэлжилж байна.



Спорт цогцолбор (бэлтгэлийн төв)-ыг барихаар “ӨВНТХ” гүйцэтгэгч байгууллагаар шалгарч 2020.05.19-нд гэрээ байгуулан спортын төвийн барилгын гадна сэндвич хавтангийн угсралт 100%, ханын өрлөг 100%, шилэн фасад 100%, дотор сантехник болон цахилгааны шугам угсралт 70%-тай нийт ажлын гүйцэтгэл 80 хувьтай үргэлжилж байна.



Хэрэгжилт 90%

ТАНИЛЦСАН:
ДАРГА

Ж.ГАНБОЛД

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.БЯМБАСАЙХАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН ГАРГАСАН:
ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

А.НАМУУН